Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 02 сарын 23-ны 52 дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ
(МАЯГТ №3)

2023 оны 08 сарын 01-ний өдөр

**УБ, ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГТ**

| № | Магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн заалт | Ш/Ү-ийн дугаар | Зөвлөмж | Хэрэгжүүлэх арга зам |
|---|---|---|---|---|
| **БҮЛЭГ 1. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ** | | | | |
| **Дэд бүлэг 1. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал** | | | | |
| 1. | Тасаг, нэгжид өндөр эрсдэл үүсгэх, ижил дуудагддаг, ижил харагддаг эмүүдийн хэрэглээнд хяналт хийдэг байх | 5.4 | Эмчилгээ, үйлчилгээнд ашиглаж байгаа өндөр эрсдэлтэй, ижил дуудагддаг, ижил харагддаг эмүүдийн шошго, хаягжилт, хадгалалтад тогтмол хяналт тавьж, эмийн аюулгүй байдлыг хангаж ажиллах | - Эмийн аюулгүй байдлын хяналтыг сайжруулж, Эмнэлгийн ерөнхий эмчийн тушаалаар баталсан хяналтын хуудсаар үнэлгээ хийж, дүгнэлт өгч ажиллах,<br>- Өндөр эрсдэлтэй, ижил дуудагддаг, ижил харагддаг эмүүдийн шошго, хаягжилт, хадгалалтын талаар эмнэлгийн хэмжээнд хийсэн зохион байгуулалт, зохицуулалтыг тасаг, нэгжид хэвшүүлэх, үзүүлэн зурагт хуудасны чанарыг сайжруулах,<br>- Эмнэлгийн мэргэжилтнүүдэд давтан сургалт хийх |
| **Дэд бүлэг 2. Тусламж, үйлчилгээний тасралтгүй байдал** | | | | |
| 2. | Амбулатори, хүлээн авах, хэвтүүлэн эмчлэх тасаг, нэгжийн зохион байгуулалтыг үйл ажиллагаа, үйлчилгээний ачаалал, эрэлт хэрэгцээ, үйлчлүүлэгчийн урсгал, хөдөлгөөнтэй уялдуулан хийсэн байх | 1.2 | Амбулатори, хүлээн авах, хэвтүүлэн эмчлэх тасгуудын 7 хоног бүр гаргадаг мэдээ, тоон үзүүлэлтүүдийг сар, улирлаар нэгтгэн, дүгнэлт өгч ажиллах | - Амбулатори, хүлээн авах, хэвтүүлэн эмчлэх тасгуудаар гаргадаг тоон үзүүлэлтүүдэд дүгнэлт өгөх<br>- Үзүүлэлтүүдийг сар, улирлаар нэгтгэн, харьцуулан дүгнэх, үйлчилгээний ачаалал, үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээ, урсгал хөдөлгөөнд тогтмол дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч, тайлагнадаг байх |
| **Дэд бүлэг 3. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, үйлчлүүлэгчийг мэдээллээр хангах** | | | | |
| 3. | Үйлчлүүлэгч тусламж, үйлчилгээний явцад биеийн, хэл ярианы, соёлын болон бусад саад бэрхшээл, чирэгдэлгүй үйлчилгээ авах нөхцөлийг хангасан байх | 2.3 | ЭМС-ын 2022 оны А/352 тоот “Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журам” тушаалыг хэрэгжүүлэх<br>ЭМС-ын 2017 оны А/512 тоот “Заавар батлах тухай” тушаалыг хэрэгжүүлэх | - Тусламж, үйлчилгээний явцад бие махбодын, соёлын, хэл ярианы бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй харьцах журмыг боловсруулж, хэрэгжүүлэх<br>- Үйлчлүүлэгчийн хувийн эд зүйлсийг хамгаалах талаар ажил зохион байгуулах |
| **Дэд бүлэг 4. Үзлэг, оношилгоо, эмчилгээ** | | | | |
| 4. | Амбулаториор хийгдэх ажилбар, үйлдлийн жагсаалттай байх | 1.3 | Амбулаториор хийгдэх мэс ажилбар, үйлдлийн жагсаалтыг баталж | - Төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ бүрээр амбулаторит хийгддэг мэс ажилбар, үйлдлийн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | мөрдөх | жагсаалтыг батлах,<br>- Мэс ажилбар, үйлдлийг оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн зааврын дагуу хийж байгаа эсэхт үнэлгээ хийх хяналтын хуудас боловсруулж, ашиглах |
| **Дэд бүлэг 5. Халдварын сэргийлэлт, хяналт** | | | | |
| 5. | Халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртсөн бол халдвараас сэргийлэх арга хэмжээ авсан байх | 2.3 | ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаалын 3-р хавсралт "Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх заавар"-ын 5-р бүлгийг хэрэгжүүлэх | - Өртөлтийн дараах сэргийлэлтэд шаардагдах хэрэгслээр бүрэн хангах,<br>- Өртөлтийн дараа авч хэрэгжүүлэх арга хэмжээний санамж анхааруулга өгөх |
| 6. | Эмнэлгийн ажилтныг жилд 1-ээс доошгүй удаа халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулдаг байх | 3.1 | ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаалын 3-р хавсралт "Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх заавар"-ын 4-р бүлгийг хэрэгжүүлэх | - Эрүүл мэндийн ажилтанг жилд 1 удаа сүрьеэ, гепатитийн B, C, D вирус, ХДХВ, тэмбүү, MRSA илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулах,<br>- Эрүүл мэндийн шинжилгээний дүнг нэгтгэн, эрүүлжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, тайлан гаргах |
| 7. | Байгууллагын орчинд цэвэрлэгээг зааврын дагуу хийдэг байх | 7.3 | ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаалын зургаадугаар хавсралт "Эрүүл мэндийн байгууллагад цэвэрлэгээ хийх заавар"-ыг хэрэгжүүлэх | - Өрөө тасалгаа бүрийг цэвэрлэгээний бүсээр ангилах, их цэвэрлэгээ хийх хуваарьтай байх,<br>- Эмнэлгийн орчинд тогтмол чийгтэй цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх |
| 8. | Тусдаа угаалгын газартай, урсгал нь зөв байх | 8.1 | ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаалын 8-р хавсралт "Эмнэлгийн зөөлөн эдлэл, цагаан хэрэглэл угаах, халдваргүйжүүлэх заавар"-ыг хэрэгжүүлэх | - Тасаг нэгжид ажилчдын хувцас угаахгүй байх<br>- Халдваргүйжүүлэх үйлчилгээгүй ахуйн зориулалтын угаалгын бодис хэрэглэж байгаа үед бохир хэрэгслийг эхэлж халдваргүйжүүлсний дараа угаах |
| 9. | Хог хаягдлыг зохих журмын дагуу зөв ангилан ялгаж цуглуулдаг байх | 9.1 | ЭМС-ын 2017 оны А/505 тоот "ЭМБ-ын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах" тушаалын 1-р хавсралтыг хэрэгжүүлэх | - ЭМС-ын тушаалд заасан дагуу аюултай хог хаягдал түр хадгалах байрны эрүүл ахуйн шаардлагыг хангах,<br>- Аюултай хог хаягдал түр хадгалах байрны гадна, дотно талд анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ хийж, шаардлагатай хэрэгслүүдийг байршуулах |
| **Дэд бүлэг 6. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ** | | | | |
| 10. | Хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, үр дүнг үнэлдэг байх | 4.1 | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн үр дүнг тооцож, хүн амын өвчлөлийн байдалд дүгнэлт өгч, тайлагнадаг байх | - Цэргийн алба хаагчид, БЗД-ийн 5 хорооны хүн амд хийсэн урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлэг үзлэгээр илэрсэн өвчлөлийн байдалд тус тус дүгнэлт өгөх,<br>- Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгооны үр дүн, дүгнэлтийг гэрээт байгууллагууд болон БЗД-ийн ЭМТ /5 ӨЭМТ-үүд/ мэдээлэх, цаашдын эмчилгээ, хяналтын талаар зөвлөмж хүргүүлэх, |
| 11. | Эрт илрүүлэг үзлэг, оношилгоог зохион байгуулж, үр дүнг үнэлдэг байх | 4.2 | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | - Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн мэдээ, тайланг сайжруулах |
| **БҮЛЭГ 2. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД** | | | | |
| **Дэд бүлэг 2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлага** | | | | |
| 12. | Тасаг, нэгж бүрийн үйл ажиллагаа, үзүүлж буй тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хэмжих өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан баталсан, хэмжилт, дүн шинжилгээ хийдэг байх | 2.2 | Үзүүлж буй эмнэлгийн үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний төрөл бүрээр чанар аюулгүй байдлын өвөрмөц үзүүлэлтийг тодорхойлж, тогтмол хэмжиж, сайжруулах арга хэмжээ авч ажиллах | - Одоо мөрдөж байгаа тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийг боловсронгуй болгож, сайжруулах,<br>- Тусламж, үйлчилгээний чанарын нийтлэг болон өвөрмөц үзүүлэлтийг тусад нь тодорхойлж, үзүүлэлтүүдийг үнэлэх аргачлалыг боловсруулж, батлах,<br>- Тасаг, нэгжийн удирдлага, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чанарын үзүүлэлтийг хэмжих аргачлал, үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх арга зүйгээр хангаж, сургалт зохион байгуулах,<br>- Тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтүүдийг улс, аймаг, нийслэл, ижил түвшиний эмнэлгүүдтэй харьцуулан дүгнэж, сайжруулах арга хэмжээ авч ажиллах,<br>- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр авсан арга хэмжээ, үр дүн, чанарын үзүүлэлтэд хийсэн дүн шинжилгээг Удирдлагын зөвлөл /даргын зөвлөл/ -ийн хурлаар жил бүр хэлэлцүүлж, холбогдох асуудлуудыг шийдвэрлүүлж байх |
| **Дэд бүлэг 3. Хүний нөөцийн хөгжил** | | | | |
| 13. | Ажилтан нэг бүрээр хувийн хэргийг бүрдүүлсэн, баяжилт хийгддэг байх | 1.7 | Ажилтнуудын хувийн хэргийн бүрдүүлэлтийг сайжруулах | - Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн хувийн хэргийг хөтлөх журам”-ыг хэрэгжүүлэх,<br>- Дээрх тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэгт байх үндсэн баримт бичгийн жагсаалт бичих хүснэгт"-ийн дагуу ажилтан бүрийн баримт бичгийн бүрдүүлэлтийг бүрэн хийж, баяжилт хийсэн тухай бүр тэмдэглэл хөтлөх |
| **Дэд бүлэг 5. Тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй ажиллагаа, засвар, техникийн үйлчилгээ** | | | | |
| 14. | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тасаг, нэгжтэй байх. | 1.1 | ЭМС-ын 2006 оны 439-р тушаалын дагуу эмнэлгийн тоног төхөөрөмжийн тасаг, нэгжтэй байх | - Байгууллагын мөрдөх бүтэц, үйл ажиллагааны стандарт, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн тоног төхөөрөмжийн тасаг, алба, нэгж /ажилтан/-ийг зохион байгуулж, батлуулсан байх,<br>- Холбогдох эрх зүйн баримтыг үндэслэн баталсан тоног төхөөрөмжийн тасаг, алба, нэгж /ажилтан/-ийн үйл ажиллагааг зохицуулах журамтай, мөрддөг байх,<br>- ЭМС-ын 2006 оны 439-р тушаалын |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | дагуу эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийн боловсон хүчнээр хангаж ажилладаг байх,<br>- Батлуулсан дүрэм, журмаа өдөр тутмынхаа үйл ажиллагаанд мөрддэг байх байх |
| 15. | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдийг мэргэшүүлэн ажиллуулсан байх | 2.1 | ЭМС-ын 2006 оны 439-р тушаалын дагуу эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдийг мэргэшүүлэн ажиллуулсан байх | - Эмнэлгийн тоног төхөөрөжийн инженерүүдийг дүрс оношилгоо, лаборатори, мэс засал, биологийн сигнал гэх мэт чиглэлээр мэргэшүүлэн ажиллуулдаг байх,<br>- ЭТТ-ийн албанд 1-ээс доошгүй мэргэшсэн инженер ажиллуулах,<br>- Мэргэшсэн байдал, мэргэжлийн зэрэг хамгаалахад тухайн байгууллага дэмжлэг үзүүлэх,<br>- Холбогдох тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах |
| 16. | Тоног төхөөрөмжийн байршил зүй зохистой байх. | 4.4 | MNS 5148:2015 -Радио давтамжтай цахилгаан соронзон орноос хүнд үзүүлэх нөлөө аюулгүйн түвшинд нийцэж буй эсэхийн үнэлгээ<br>MNS 5148:2002 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Радио сүлжээний цахилгаан соронзон орон. Ажлын байрны зөвшөөрөх түвшин, хяналт тавих шаардлага<br>Тоног төхөөрөмжийн байршил зүй зохистой байх | - Цахилгаан болон электрон тоног төхөөрөмжүүдийг үйлдвэрлэгчийн заавар, зөвлөмжийн дагуу байрлуулах,<br>- Тухайн тоног төхөөрөмжүүдийн орчиндоо үүсгэх цахилгаан соронзон оронтой нь харьцангуйгаар талбайд байрлуулах,<br>- Хэт мэдрэмтгий тоног төхөөрөмжүүдтэй тасгийн зохион байгуулалтанд анхаарч ажиллах,<br>- Ажлын байрны зөвшөөрөх түвшин, хяналт тавих шаардлагыг баримтлаж ажиллах |
| 17. | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэмжилт, туршилтанд хамруулах | | ЭМС-ын 2015 оны 149-р тушаалын дагуу эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэмжилт, туршилтанд хамруулах | - ЭМС-ын 2015 оны 149-р тушаалын дагуу эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг нэг бүрчлэн баталгаажуулалтанд хамруулах,<br>- Зохих хөрөнгийг төсөвт суулгах,<br>- Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах |
| 18. | Тоног төхөөрөмж бүрийг газардуулгын системд холбож, аюулгүй ажиллагааг хангасан байх. | 4.5 | MNS/IEC 60364-7-710:2014 Барилгын цахилгаан төхөөрөмж. Эмнэлгийн байрны эмчилгээний зориулалттай цахилгаан тоног төхөөрөмжийн байрлалд тавих шаардлага, MNS 5146:2002 “Цахилгааны аюулгүй ажиллагаа. Хамгаалах газардуулга тэлэлт<br>Тоног төхөөрөмж бүрийг | - Мэргэжлийн байгууллагаар жилд 2-оос доошгүй (өвөл, зун) удаа цэг тус бүр дээр газардуулгын хэмжилт хийлгэж, дүгнэлт гаргуулсан байх,<br>- Цахилгаан дамжуулах утасны бүрэн байдал, хүн хүрэлцэх (унтраалга, сэлгэн залгах автомат зэргийн битүүмжлэл) хэсгийн аюулгүй байдлыг хангах,<br>- Тоног төхөөрөмжийг ажиллуулахдаа газардуудах байгууламжид холбож хэвших,<br>- Газардуулах байгууламжийн эсэргүүцэл зохих хэмжээндээ байгаа |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | газардуулгын системд холбож аюулгүй ажиллагааг хангасан байх | эсэхэд мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэн (хэзээ ч хэмжихэд 4 Ом-оос ихгүй эсэргүүцэлтэй байх техникийн нөхцлийг бүрдүүлэх) хяналт тавих,<br>- Статик цэнэгт өртөхөөс урьдчлан сэргийлэх зохих арга хэмжээнүүдийг хэрэглэж хэвших |
| **Дэд бүлэг 6. Барилга, инженерийн байгууламжийн аюулгүй ажиллагаа** | | | | |
| 19. | Цахилгааны нөөц тэжээлийн найдваржилт хангагдсан байх | 2.2 | Цахилгааны нөөц тэжээлийн найдваржилтыг хангах | - Эмнэлгийн АВР /Автомат сэлгэн залгагч/-ийн ажиллах техникийн болон схем зурагтай байх<br>- Нөөц тэжээлийн хүчин чадал нь тухайн байгууллагын /тасгийн/ тоног төхөөрөмжийн суурилагдсан хүчин чадлаас багагүй байх<br>- Нөөц тэжээлийн сэлгэн залгалтын шуурхай ажиллагаа, найдваржилтыг хангаж буйг мэргэжлийн байгууллагын зохих туршилтаар баталгаажуулах |
| 20. | Цахилгаан энергийн чанарын шаардлагад нийцсэн байх. | 2.3 | Цахилгаан энергийн чанарын шаардлага MNS 1778:2007 стандартад нийцсэн нийцсэн байх. | - Эмнэлгийн цахилгаан тэжээл нь MNS 1778:2007 стандартад нийцсэн эсэхийг мэргэжлийн байгууллагаар улирал бүр хэмжилт, туршилт хийлгэж цахилгаан тэжээлийн чанарыг дээшлүүлэх арга хэмжээ авдаг байх,<br>- Хэмжилт хийх цэгүүдийг цахилгаан энергийн чанар доголдож болзошгүй /мэдрэмтгий/ хэрэглэгчид хийлгэдэг (ЭКГ, ЭХО, КТ...) байх,<br>- Цахилгаан энергийн чанарыг доголдуулж болзошгүй /шугаман бус/ хэрэглэгчийн (рентген, UPS, физик эмчилгээний тоног төхөөрөмжүүд) оролт дээр хэмжилт, туршилт хийлгэж цахилгаан тэжээлийн чанарын шаардлагыг хангаж байгаа эсэхийг нотлосон байх. |
| 21. | Галын аюулгүй байдал, гал унтраах техник, хэрэгслийг ашиглах талаар ажилтнуудыг сургалтанд хамруулсан байх. | 4.1 | MNS 4244:1994 “Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага “Галын аюулгүй байдал, гал унтраах техник, хэрэгслийг ашиглах талаар ажилтнуудыг сургалтанд хамруулсан байх. | - Байгууллагын хэмжээнд мөрддөг галын аюулгүй ажиллагааны батлагдсан заавраа мөрдөх,<br>- Харьяалах нутаг дэвсгэрийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран ажилтнуудад жилд 1-2 удаа галын аюулгүй байдлын дадлага, сургалтыг зохион байгуулж, баримтжуулах,<br>- Галын аюулаас урьдчилан сэргийлэх буланг шаардлагатай цэгүүдэд байршуулах,<br>- Гал унтраах хэрэгслийг зааврын дагуу ашиглах дадал, чадварыг эзэмших |
| 22. | Галын хорыг шаардлагатай өрөө, нэгжид зохих журмын дагуу байрлуулж, хорыг цэнэглэсэн ба | 4.5 | MNS 4244:1994 “Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага “Галын аюулгүй байдал, гал унтраах техник, | - Галын хорны хүртээмжийг эрс нэмэгдүүлэх<br>- Шаардлагатай цэгүүдэд галын хорыг байршуулсан<br>- Галын хорыг цэнэглэсэн ба ашигласан |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ашигласан бүртгэлийг хөтөлдөг байх | | хэрэгслийг ашиглах талаар ажилтнуудыг сургалтанд хамруулсан байх. | бүртгэл, тэмдэглэл хөтөлсөн<br>- Нэг бүрчлэн техник ашиглалтын паспорт хөтөлсөн тэмдэглэлтэй<br>- Галын хорыг худалдан авсан, цэнэглэсэн санхүүгийн баримттай |
| **БҮЛЭГ 3. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЕХНОЛОГИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД** | | | | |
| **Дэд бүлэг 2.Амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээ** | | | | |
| 23. | Амилуулах тусламжийг үзүүлэх мэргэжлийн багийг зохион байгуулж, дадлагажуулдаг байх. | 3.1 | ЭМС-ын 2021 оны А/814 тоот тушаал болон насанд хүрэгчдийн Амилуулах суурь тусламжийн удирдамжийг мөрдөж ажиллах | - Өөрийн эмнэлгийн онцлогт тохирсон яаралтай тусламжийн багийг зохион байгуулах, дуудлагын тогтолцоог нэвтрүүлэх |
| 24. | Тусламж, үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангасан байх | 4.1 | Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 6330:2017 стандарт, ЭМС-ын 2019 оны А/293 тоот тушаалын гуравдугаар хавсралтад заасан эм, эмнэлгийн хэрэгслээр хангах | - Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцөөр бүрэн хангах<br>- Хадгалалт, зарцуулалтад хяналт тавих |
| 25. | Тусламж үзүүлэхэд шаардлагатай автомашины бэлэн байдлыг хангаж дохиолол, дуудлагын системийг байрлуулсан байх. | 4.5 | Түргэн тусламжийн автомашиныг “Түргэн тусламжийн төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6717:2018 стандарт”-ын В хавсралтын дагуу тоноглох, шаардлагатай багаж, эм, эмнэлгийн хэрэгсэлээр хангах | - Түргэн тусламжийн автомашиныг стандарт шаардлагын дагуу тоноглож, өдөр тутмын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах, хяналт тавих,<br>- ЭМС-ын 2019 оны А/294 тоот тушаалын хавсралтад заасан багаж, эм, эмнэлгийн хэрэгслээр бүрэн хангах,<br>- Автомашины цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг тогтмол хийж, тэмдэглэл хөтлөх |
| **Дэд бүлэг 2. Сувилахуйн тусламж, үйлчилгээ** | | | | |
| 26. | Сувилахуйн тусламж, үйлчилгээнд хяналт, үнэлгээ хийж үр дүнг тооцсон байх | 3.4 | Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгон үр дүнг тооцох | - Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарын өвөрмөц шалгуур үзүүлэлтийг шатлалын дагуу гаргаж, улирал, хагас жил тутамд үнэлж дүгнэх, үзүүлэлтийг сайжруулах олон талт арга хэмжээг зохион байгуулах |
| **Дэд бүлэг 3. Эмийн менежмент ба зохистой хэрэглээ** | | | | |
| 27. | Үйлчлүүлэгчийг зөв таньж эмийн эмчилгээ хийх нөхцлийг бүрдүүлсэн байх | 3.3 | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/352 тоот тушаалыг ажилтан бүр мөрдөн ажиллах | - Эмчилгээ, ажилбар үйлдэл хийхийн өмнө үйлчлүүлэгчийг танин тодруулж хэвших,<br>- Улирал тутам эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт хийж, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах |
| 28. | Эм, эмнэлгийн хэрэгсэлд чанарын хяналт үнэлгээ хийдэг байх | 3.9 | Эм эмнэлгийн хэрэгслийн чанарт Дотоод хяналтын баг төлөвлөгөөт хяналтыг тогтмол хийх | - Улирал, хагас жилээр хяналт үнэлгээг хийж дүгнэлт өгч ажиллах |
| **Дэд бүлэг 5. Эмчилгээний хоол** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 29. | Үйлчлүүлэгчид зориулсан эмчилгээний хоолны цэсийг өвчний нэршлээр боловсруулж баталсан, аргачлалын дагуу хийдэг байх | 3.1 | ЭМС-ын 2018 оны А/16 тоот “Эмчилгээний хоолны удирдамж батлах тухай” тушаалын 3-р хэсгийг хэрэгжүүлэх | - Өвчний нэршлээр боловсруулсан эмчилгээний хоолны цэстэй болох<br>- Хоол тус бүрээр технологи карттай, аргачлалын дагуу хийдэг байх |
| **Дэд бүлэг 7. Мэдээгүйжүүлэг, мэс заслын тусламж, үйлчилгээ** | | | | |
| **Б. МЭС ЗАСЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ** | | | | |
| 30. | Мэс заслын хүндрэл, давтан хагалгааны талаар хэлэлцэж, дүгнэлт өгдөг байх | 3.10. | Мэс заслын давтан хагалгаа, мэс заслын хүндрэлийн тохиолдол бүрт эмнэлзүйн хэлэлцүүлэг хийж, мэс заслын хүндрэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах | - Давтан хагалгаа, мэс заслын хүндрэлийн тохиолдол бүрийн эмнэлзүйн хэлэлцүүлгийг хийж тэмдэглэл хөтлөх,<br>- Хэлэлцүүлгээс гарсан шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллах,<br>- Мэс заслын хүндрэлээс сэргийлэх, бууруулах бодиттой арга хэмжээ авч ажиллах |
| **Дэд бүлэг 8. Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ** | | | | |
| 31. | Эд, эсийн шинжилгээ хийдэг, шинжилгээний дүгнэлтийг үйлчлүүлэгчид мэдээлдэг байх | 13.8. | Амьд сорьцын шинжилгээ хийх журмыг мөрдөж ажиллах<br>ЭМС-ын 2017 оны “Амьд сорьц, эмгэг эс судлалын шинжилгээ хийх журмыг шинэчлэн батлах тухай” А/07 дугаар тушаалын холбогдох заалтыг мөрдөх, | - ЭМС-ын тушаалаар баталсан маягтыг хөтөлж, шинжилгээг хүлээлгэн өгсөн бүртгэл хөтлөх,<br>- Шинжилгээний онош, дүгнэлтийг хүлээн авсан, үйлчлүүлэгчид мэдээлсэн тухай бүртгэл, мэдээллийг сайжруулах |
| 32. | Гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө өгөх таатай орчин бүрдүүлсэн байх | 17.2. | Үйлчлүүлэгчдийг гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө, мэдээллээр хангах | - Гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө өгөх өрөөтэй болох, сургалт явуулах шаардлагатай тоног төхөөрөмж, гарын авлага, үзүүлэн материалыг сайжруулах<br>- ГБТ сургалт хийсэн бүртгэл хөтлөх, дүгнэх |
| 33. | Хөх, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэг хийдэг, дүгнэлт өгч ажилладаг байх | 20.2 | Эмэгтэйчүүдэд хөхний үзлэг хийх, хөхний өмөнгөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах | - Эмэгтэйчүүдэд хөхөө шалгах аргыг заах сургах, хөхний үзлэг хийх, бүртгэл хөтлөх,<br>- Хөхний өмөнгөөс сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх,<br>- Судалгаа, дүгнэлттэй ажиллах |
| **Дэд бүлэг 9. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ** | | | | |
| 34. | Уламжлалт анагаах ухаан тусламж үйлчилгээнд мөрддөг дүрэм журам хийх засал үйлдлийн жагсаалтын хэрэгжилтэнд хяналт тавьдаг байх | 1.4 | ЭМС-ын 2020 оны А/486, А/487, ЭМС-ын 2021 оны А/152 тоот тушаалаар баталсан эмчилгээний зааврууды мөрдөж ажиллах | - Уламжлалт анагаах ухааны заслын нэр төрлийг нэмэгдүүлэх, жагсаалт батлах,<br>- Мэргэжлийн эмч мэргэжилтнээр хангах,<br>- Засал хийх өрөөг стандартын дагуу тохижуулах, шаардлагатай хэрэгслээр хангах,<br>- Үйлдлийн гүйцэтгэлийг хяналтын хуудсаар үнэлж, дүгнэлт өгч хэвших |
| | Улсын бүртгэлд бүртгэгдсэн чанарын | 7.1 | Чанарын баталгаатай уламжлалт эмээр хангах | - Анхдагч савалгаатай, сери тавигдсан Уламжлалт эмийг чанарын |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 35. | баталгаатай монгол уламжлал эм эмнэлгийн хэрэгслээр хангасан байх | | | баталгаатай үйлдвэрээс авч эмчилгээнд хэрэглэх,<br>- Эм эмнэлгийн хэрэгсэлд хяналт хийх |
| 36. | Уламжлалт эм, тангийн хадгалалтын горимыг баримталдаг байх | 7.2 | Уламжлалтын эм танг хадгалах нөхцөлийг стандарт шаардлагын дагуу сайжруулах | - Уламжлалтын эм танг зөв горимоор хадгалах,<br>- Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага MNS 5260:2015 сандартын холбогдох заалтыг хэрэгжүүлэх,<br>- Өрөөний чийгшил температурыг тогтмол хэмжих |
| 37. | Уламжлалт эмийн зохистой хэрэглээг тухайн эмгэгийн эмнэлзүйн удирдамжийн дагуу хэрэгжүүлсэн байх | 7.3 | ЭМС-ын 2019 оны А/378 дугаар тушаалаар баталсан зааврыг мөрдөх,<br>УАУ-ы зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн удирдамжийг баримтлах; | - Уламжлалт анагаахын оношилгоо, эмчилгээний эмнэл зүйн зааврын дагуу эмчилгээний зарчмыг зөв сонгон эм заслыг зохистой сонгох,<br>- Эм танг хүртэх ёс жаяг болон гам дэглэмийн талаарх мэдээллийг хэвтэн эмчлэгдэж байгаа үйлчлүүлэгчдэд өгч, эм заслын үр дүнг тооцох,<br>- Үйлчлүүлэгчдэд уламжлалт эмийн зохистой хэрэглээний талаар сургалт хийж, бүртгэлжүүлсэн байх,<br>- Өөрсдийн боловсруулсан гарын авлага, материалтай байх,<br>- Уламжлалт эмийн хэрэглээнд судалгаа хийх, үр дүн тооцох |
| **Дэд бүлэг 12. Хүүхдийн тусламж, үйлчилгээ** | | | | |
| 38. | Хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн, ур чадвартай эмнэлгийн мэргэжилтнээр хангагдсан байх | 2.1 | Хүүхдийн тасгийн нийт эмч, сувилагч нарыг сургалтад тасралтгүй хамруулж, ур чадварыг дээшлүүлэх | - Хүүхдийн тасгийн эмч, сувилагч нар хүүхдийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, ХӨЦМ зэрэг сургалтад хамруулах,<br>- Эмч нарын ур чадварыг дээшлүүлж, мэргэшлийн зэрэг хамгаалахад дэмжлэг үзүүлэх |
| 39. | Хүүхдийг унаж бэртэх эрсдлээс сэргийлсэн арга хэмжээг авсан байх. | 5.2 | Хүүхдийн тасагт аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах | - Хүүхдийг унаж бэртэх эрсдлээс сэргийлсэн орчинг бүрдүүлэх /өрөөний цонх, шатны хаалт, хаалганы довжоо, ариун цэврийн өрөө, шалны материал/<br>- Унах эрсдэлтэй хүүхэд, сэргийлэх аргыг тодорхойлсон, ашигладаг байх,<br>- Эрсдэлийн үнэлгээ хийдэг байх |
| **Дэд бүлэг 13. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ** | | | | |
| 40. | Тасаг, нэгжид тусламж үйлчилгээний чанараа сайжруулах олон талт ажлыг төлөвлөн зохион байгуулдаг байх | 3.2 | ЭМС-ын А/566 дугаар тушаалын 3, 4-р хавсралтыг хэрэгжүүлэх | - ЭМТҮ-ний чанар, аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулж нийт ажилтнуудыг хамруулах,<br>- ЭМТҮ-ний чанар сайжруулах арга /тухайлбал: ижил мэргэжилтний үзлэг/-ыг үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлж, үр дүнг тооцох,<br>- Тасгийн чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлж, тайлангнаж байх |
| 41. | Тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтэд дүн шинжилгээ тогтмол хийж, сайжруулах | 3.3 | Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийг | - Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хэмжих өвөрмөц шалгуур үзүүлэлтийг боловсруулах, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ажлыг төлөвлөх | | боловсруулж, батлах | - Шалгуур үзүүлэлтийг тогтмол хэмжиж, дүгнэж байх,<br>- Чанарын шалгуур үзүүлэлтийг улс, нийслэл, олон улсын түвшинд харьцуулан судалж, дүгнэлттэй ажиллах |
| **Дэд бүлэг 15. Арьс арьсан доорхи эслэгийн үеийн тусламж үйлчилгээ** | | | | |
| 42. | Тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтэд дүн шинжилгээ тогтмол хийж, сайжруулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлдэг байх | 3.3 | Чанарын үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж сайжруулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх | - Тасаг нэгжийн чанарын үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийж сайжруулах арга хэмжээ авах,<br>- Сайн туршлага нэвтрүүлэх |
| 43. | Ноцтой хүндрэл гарах эрсдэлтэй, хүнд, маш хүнд өвчтний оношилгоо эмчилгээг шийдвэрлэхэд эмч нарын хамтарсан үзлэг, хэлэлцүүлэг хийдэг байх | 4.6 | Эмч нарын хамтарсан үзлэг хийдэг байх | - Эмчлүүлэгчийн биеийн байдал хүндэрсэн нөхцөлд эмч нарын хамтарсан үзлэг хийдэг байх,<br>- Үзлэгийн тэмдэглэлийг хийж баталгаажуулж байх |
| 44. | Үйлчлүүлэгч тусламж, үйлчилгээ авах дуудлагын хонхтой байх | 4.8 | Тасагт дуудлагын системтэй байх | - Эмчилгээний болон мэс ажилбарын өрөөнд эмч дуудах хонхтой болох,<br>- Эмч сувилагч дуудлагыг хүлээж авч тусламж үзүүлдэг байх |
| **Дэд бүлэг 14. Хавдарын тусламж, үйлчилгээ** | | | | |
| 45. | Тасаг, нэгжийн үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээг зохицуулах журамтай, хэрэгжилтэд хяналт тавьдаг байх | 1.3. | Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6330:2017 стандартын 11 дахь заалтыг хэрэгжүүлэх | - Хавдрын кабинетын үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээг зохицуулах журамтай ажиллах,<br>- Тусламж, үйлчилгээний жагсаалтыг баталж, мөрдөх |
| 46. | Эрчимт эмчилгээний өрөөг зохион байгуулсан, шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангасан байх | 4.7 | Тусламж үйлчилгээ үзүүлж байгаа тасаг, нэгжид эрчимт эмчилгээний өрөөг зохион байгуулах | - Эрчимт эмчилгээний өрөөнд байх шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, бэлэн байдлыг ханган ажиллах |
| **Дэд бүлэг 17. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ** | | | | |
| 47. | Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн, ур чадвартай эмнэлгийн мэргэжилтнээр хангагдсан байх | 2.1. | Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6330:2017 стандартын 12.10 дахь заалт, ЭМС-ын 2015 оны 329 тоот тушаалаар баталсан зааврыг мөрдөх | - Хөнгөвчлөх эмчилгээний чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэх, сургалтанд хамруулах |
| **Дэд бүлэг 19. Нүүр амны тусламж үйлчилгээ** | | | | |
| 48. | Тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтэд дүн шинжилгээ тогтмол хийж, сайжруулах ажлыг төлөвлөн | 3.3 | Тусламж, үйлчилгээний чанарын өвөрмөц үзүүлэлтийг боловсруулж, дүгнэж байх | - Тасаг нэгжийн чанарын үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийж сайжруулах арга хэмжээ авах,<br>- Бусад байгууллага, мэргэжилтнүүдээс суралцах, сайн туршлага нэвтрүүлэх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлдэг байх | | | |
| 49. | Ноцтой хүндрэл гарах эрсдэлтэй, хүнд, маш хүнд өвчтний оношилгоо эмчилгээг шийдвэрлэхэд эмч нарын хамтарсан үзлэг, хэлэлцүүлэг хийдэг байх | 4.6 | Эмч нарын хамтарсан үзлэг хийдэг байх | - Эмчлүүлэгчийн биеийн байдал хүндэрсэн нөхцөлд эмч нарын хамтарсан үзлэг хийж, шийдвэрийг баримтжуулж, бүртгэл хөтлөх,<br>- Үзлэгийн тэмдэглэлийг хийж баталгаажуулж байх |
| 50. | Үйлчлүүлэгч тусламж, үйлчилгээ авах дуудлагын хонхтой байх | 4.8 | Дуудлагын системтэй байх | - Эмчилгээний болон мэс ажилбарын өрөөнд эмч дуудах хонхтой байх,<br>- Эмч, сувилагч дуудлагыг хүлээж авч тусламж үзүүлдэг байх |
| **Дэд бүлэг 20.Чих хамар хоолойн тусламж, үйлчилгээ** | | | | |
| 51. | Байгууллагын хэмжээнд зохион байгуулах үйл ажиллагаанд оролцдог байх | 3.1 | ЭМС-ын А/566 дугаар тушаалыг хэрэгжүүлэх<br>Эмнэлгийн ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод чанар, аюулгүй байдлын чиглэлээр хийх ажлыг тусгах | - Бүх ажилтны албан тушаалын тодорхойлолтод чанар, аюулгүй байдлын чиглэлээр хийх ажлыг тодорхой тусгах,<br>- ЭМТҮ-ний чанар, аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулж нийт ажилтнуудыг хамруулах<br>- ЭМТҮ-ний чанар сайжруулах аргыг үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлж, үр дүнг тооцох /ИМҮ, Фокус бүлгийн ярилцлага, аян, өдөрлөг/ |
| 52. | Тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтэд дүн шинжилгээ тогтмол хийж, сайжруулах ажлыг төлөвлөх | 3.3 | ЭМС-ын 2019 оны А/566 тоот тушаалын хэрэгжилтийг тасаг нэгжид хангах,<br>Тасаг нэгж бүрийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлох | - Чих хамар хоолой эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хэмжих өвөрмөц шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлох,<br>- Шалгуур үзүүлэлтийн дагуу улирал бүр дүгнэлт өгч, сайжруулах арга хэмжээ авч ажиллах,<br>- Чанарын шалгуур үзүүлэлтийг улс, нийслэл, олон улсын түвшинд харьцуулан судалж, дүгнэлттэй ажиллах |
| **Дэд бүлэг 21. Дүрс оношилгоо** | | | | |
| 53. | Байгууллагын хэмжээнд хэрэгждэг чанар сайжруулах хөтөлбөрийг дэмждэг, үйл ажиллагаанд оролцдог байх | 1.3 | Чанар аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагаанд бүх ажилтныг оролцуулдаг байх | - Эмнэлгийн бүх ажилтны албан тушаалын тодорхойлолтод тусламж, үйлчилгээний чанар сайжруулах үйл ажиллагааны оролцоог тодорхой тусгаж баталгаажуулах,<br>- Тусламж үйлчилгээний чанар сайжруулах үйл ажиллагааны оролцсон байдлыг ажилтны ажил дүгнэх шалгуурт оруулан үнэлдэг болох |
| 54 | Шинжилгээний өмнөх, шинжилгээний, шинжилгээний дараах гүйцэтгэлийг үнэлэх чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлж, хяналт тавин үр дүнг тооцон ажилладаг байх | 4.5 | Шинжилгээг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сайжруулан батлах, үр дүнг тооцож байх | - Шинжилгээний өмнөх, шинжилгээний үеийн, шинжилгээний дараах үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох,<br>- Сар, улирлаар дүгнэх,<br>- Шалгуур үзүүлэлтээ шинэчилэн боловсруулж батлах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Дэд бүлэг 22. Сэргээн засах тусламж үйлчилгээ** | | | | |
| 55. | Оношилгоо, үнэлгээ, эмчилгээг стандарт, эмнэлзүйн зааврын дагуу хийдэг байх | 4.3 | Сэргээн засахын тусламж үйлчилгээг стандарт заавры дагуу хийх | - MNS 4621:2008 эмчилгээ оношилгооны түгээмэл үйлдлийн стандартын дагуу тусламж үйлчилгээг зөв үзүүлэх,<br>- Тусламж үйлчилгээний аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөх,<br>- Хөдөлгөөн заслын эмчилгээ хийдэг болох |
| 56. | Сэргээн засах тусламж үйлчилгээний үр дүнг тооцдог байх | 4.4 | Сэргээн засах эмчилгээний үр дүнг тооцох | - Амбулаториор болон хэвтүүлэн эмчлүүлэгчдэд үзүүлсэн сэргээн засах эмчилгээний төрөл бүрээр үр дүнг тооцох<br>- Үр дүнгийн харьцуулсан дүгнэлт судалгаатай |
| **Дэд бүлэг 23. Цус сэлбэлт судлалын тусламж, үйлчилгээ** | | | | |
| 57. | Тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн мэргэжилтэн нь мэргэшсэн/ сургагдсан, ур чадвартай байх | 3.1. | Цус цусан бүтээгдэхүүн хариуцсан эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж бэлтгэх | - Цус цусан бүтээгдэхүүн хариуцсан эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургалтанд хамруулах, бэлтгэх,<br>- Эмнэлгийн мэргэжилтнүүдэд ЦЦБ-ны хэрэглээ, аюулгүй байдлын талаар тогтмол сургалт хийх |

Шинжээчдийн баг**:** /Нэр, гарын үсэг/

Ахлагч: Г.Оюунцэцэг

Гишүүн: Д.Чулуунхүү

Ж.Долгормаа

Ж.Батноров

Б.Тэгшжаргал

С.Оюунгэрэл

Д.Пүрэвдаш